



## НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

### Чанарын гарын авлага шинэчлэн батлах тухай

Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн Хавсралт 3-ын стандарт шаардлага, Олон улсын агаарын навигацийн цаг уурын үйлчилгээний Чанарын удирдлагын тогтолцооны шаардлагыг хэрэгжүүлэх гарын авлага Док 9873, "ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандарт", "Нислэгийн цаг уурын төвийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай" Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2023 оны А/235 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Нисэхийн цаг уурын үйлчилгээнд "ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандарт"-ыг хэрэгжүүлэх зорилгоор шинэчлэн найруулсан "Чанарын гарын авлага"-ыг хавсралтаар баталсугай.
- Чанарын гарын авлагыг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аюулгүй байдал, чанарын менежер (Б.Батцэцэг)-т үүрэг болгосугай.
- Энэхүү тушаал гарсантай холбогдуулан төвийн Даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлагдсан "Чанарын гарын авлага"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БАНЬДСҮРЭН

Нислэгийн цаг уурын төв



# Чанарын гарын авлага

(QUALITY MANUAL)

ЧГА-01

УЛААНБААТАР 2024



## БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

Энэхүү хуудас нь "ЧАНАРЫН ГАРЫН АВЛАГА"-ын хамт хүчин төгөлдөр байна.

Байгууллага: Нислэгийн цаг уурын төв

"НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВ"-ИЙН  
ЧАНАРЫН ГАРЫН АВЛАГА

Боловсруулсан	Хянасан	Баталсан
1	2	3
Албан тушаал: Аюулгүй байдал, чанарын хяналтын ахлах мэргэжилтэн Нэр: Д.Ганбат Гарын үсэг: Нэр: Н.Энхдалай Гарын үсэг: Огноо: 2024.11.28	Албан тушаал: Аюулгүй байдал, чанарын менежер Нэр: Б.Батцэцэг Гарын үсэг: Огноо: 2024.11.29	Албан тушаал: Төвийн дарга Нэр: Б.Баньдсүрэн Гарын үсэг: Огноо: 2024.11.29



## БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн дэлгэрэнгүй Document Details					
1	2	3			
1	Баримт бичгийн нэр Document Name	Нислэгийн цаг уурын төвийн Чанарын гарын авлага			
2	Баримт бичгийн зорилго Purpose of the Document	Энэхүү гарын авлагын зорилго нь: Нислэгийн цаг агаарын мэдээний хангалтын хэвийн ажиллагааг хангахад оршино.			
3	Баримт бичгийн код Unit Identification	НЦУТ-ЧГА-001:2024			
4	Хуудасны тоо Total page	Хуудас 64			
5	Хэлбэр Document Status	Хэвлэмэл А-4			
6	Хадгалалт Archive	Төвийн цахим архивын хавтсанд эх хэлбэрээр хадгална. (AMC/Barimtjuulsan juram)			
7	Хариуцах албан тушаалтан Document Owner	Аюулгүй байдал, чанарын менежер			
8	Батлагдсан огноо Date approved	2024.11.29			
9	Баталсан байгууллага, албан тушаалтан Approved by	Нислэгийн цаг уурын төвийн дарга			
10	Өөрчлөлт, нэмэлт орсон байдал Amendments	-			
11	Баримт бичгийн бүтэц Document Structure	Бүлэг 9			
12	Хавсралт	3			
13	Тараагдсан байдал Distribution	Хэлтэс, алба Division name	Хяналтын дугаар	Хувь Version	Гарын үсэг Signature
		Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс	1	2	
		Аюулгүй байдал, чанарын хяналтын хэсэг	2	1	
		Мэдээлэл, үйлчилгээний хэлтэс	3	2	
		Нисэхийн цаг уурын бодит ажиглалтын үйлчилгээний хэсэг	4	2	
		Морин-Уул локатор, цаг уурын станц	5	1	
		Нийт Total			8

**ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН БҮРТГЭЛ**

Нислэгийн цаг уурын төвийн “Чанарын гарын авлага”-д орсон нэмэлт, өөрчлөлтийг уг журмыг хянасан албан тушаалтан хянан баталгаажуулна.

Шаардлагатай бол журмыг баталгаажуулсан албан тушаалтанд танилцуулж, зөвшөөрөл авсан байна.


Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ажилтан доорх хүснэгтийг заавал бөглөсөн байх шаардлагатай.

№	Өөрчлөлт	Өөрчлөлт оруулсан огноо	Тайлбар	Гарын үсэг
1	2	3	4	5
1	Хэвлэл 1	2013.06.07	Анхны хэвлэл	П.Сэржмядаг
2	Хэвлэл 1 Өөрчлөлт 01	2013.08.20	Хуудас 13, 14, 22, 51, 54	П.Сэржмядаг
3	Хэвлэл 1 Өөрчлөлт 02	2013.10.01	Хуудас 48	П.Сэржмядаг
4	Хэвлэл 2	2016.11.01	51%-аас дээш	П.Сэржмядаг
5	Хэвлэл 3	2017.12.28	51%-аас дээш	П.Сэржмядаг
6	Хэвлэл 4	2024.11.28	51%-аас дээш	Б.Батцэцэг



## ГАРЧИГ

## БҮЛЭГ 1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ



1.1	Хамрах хүрээ	9
1.2	Норматив ишлэл	10
1.3	Нэр томьёо, тодорхойлолт	11
1.4	Товчилсон үгс	14

## БҮЛЭГ 2 БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВ БАЙДАЛ




2.1	Байгууллагын төлөв байдал	16
2.2	Сонирхогч талууд	16
2.3	Чанарын удирдлагын тогтолцооны хамрах хүрээ	16
2.4	Чанарын удирдлагын тогтолцоо ба үйл явц	17

## БҮЛЭГ 3 МАНЛАЙЛАЛ



3.1	Манлайлал ба амлалт	19
3.2	Чанарын бодлого	20
3.3	Байгууллага дахь үүрэг хариуцлага, эрх мэдэл	20

## БҮЛЭГ 4 ТӨЛӨВЛӨЛТ



4.1	Эрсдэл ба боломж	25
4.2	Чанарын зорилт	25
4.3	Өөрчлөлтийг төлөвлөх	27

## БҮЛЭГ 5 ТУЛГУУР ХҮЧИН ЗҮЙЛ



5.1	Нөөц	29
5.2	Чадамж	31
5.3	Мэдлэг ойлголт	31
5.4	Холбоо харилцаа	32
5.5	Баримтжуулсан мэдээлэл	33



## БҮЛЭГ 6 АЖИЛЛАГАА




6.1	Ажиллагааны төлөвлөлт ба хяналт	36
6.2	Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлага	36
6.3	Үйлчилгээний дизайн ба боловсруулалт	37
6.4	Гаднаас нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ	40
6.5	Үйлчилгээ үзүүлэх	41
6.6	Бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж бэлтгэх	43
6.7	Үл тохирол бүхий гаралтын хяналт	43

## БҮЛЭГ 7 ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ




7.1	Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ	46
7.2	Дотоод аудит	46
7.3	Удирдлагын дүн шинжилгээ	47

## БҮЛЭГ 8 САЙЖРУУЛАЛТ



8.1	Ерөнхий зүйл	50
8.2	Үл тохирол ба залруулах арга хэмжээ	50
8.3	Байнгын сайжруулалт	50

## БҮЛЭГ 9 ХАВСРАЛТУУД



9.1	НЦУТ-ийн бүтэц, зохион байгуулалт (Хавсралт 1)	53
9.2	Үйл явцын схем зураг (Хавсралт 2)	54
9.3	Үйл явцын дэс дараалал, харилцан үйлчлэлийн нөхцөл шаардлага (Хавсралт 3)	54
9.4	Дотоод бичиг баримтын жагсаалт (Хавсралт 4)	55



	<b>Нислэгийн цаг уурын төв</b>
	<b>Монгол улс</b>
	<b>Улаанбаатар хот</b>
	<b><u><a href="http://www.amc.natem.gov.mn">www.amc.natem.gov.mn</a></u></b>
	<b><u><a href="mailto:amc@natem.gov.mn">amc@natem.gov.mn</a></u></b>
	<b>(976)-71285024</b>
	<b>(976)-70049869</b>




# БҮЛЭГ 1

## Ерөнхий зүйл



## 1.1 Хамрах хүрээ

Энэхүү Чанарын гарын авлага нь НЦУТ-д Чанарын удирдлагын тогтолцоог MNS ISO 9001:2016 стандартын дагуу хэрэгжүүлэн чанарын шаардлага хангасан цаг уурын мэдээ мэдээллээр нислэгийг хангах, нислэгийн аюулгүй ажиллагааг хангасан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдсэн үндсэн баримт бичиг бөгөөд тус төвийн бүх хэлтэс нэгжийн албан хаагчид дагаж мөрдөнө.



Энэхүү гарын авлагад заасны дагуу холбогдох баримт бичгүүдийг чанарын удирдлагын тогтолцооны хүрээнд боловсруулах, магадлан шалгаж батлах, бүртгэх, хэрэглэх, хянаж шалгах, нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд төвийн үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлнэ. Чанарын удирдлагын тогтолцоог байнга сайжруулж байх үйл явцыг оруулаад уг тогтолцоог үр нөлөөтэй хэрэглэн хэрэглэгчийн болон холбогдох хууль тогтоомжийн шаардлагад тохирох байдлыг хангах замаар

хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.

Баримт бичгүүдийг чанарын удирдлагын тогтолцооны хүрээнд боловсруулах, магадлан шалгаж батлах, бүртгэх, хэрэглэх, хянаж шалгах, нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг хамарсан чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.

## Чанарын гарын авлагын тараалт

Тус төвийн чанарын гарын авлагын хяналттай хувь нь дараах байдлаар тараагдсан болно.





## 1.2 Норматив ишлэл

Энэхүү Чанарын гарын авлагад дараах баримт бичгүүдийг иш татсан. Иш татсан баримт бичгүүдийн хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:


- "Иргэний нисэхийн тухай" Монгол улсын хууль
- "Хөдөлмөрийн тухай" Монгол улсын хууль
- Нислэгийн цаг уурын төвийн "Хөдөлмөрийн дотоод журам" НЦУТ-БЖ-007:2020
- Нислэгийн цаг уурын төвийн "Ерөнхий заавар" НЦУТ-ЕЗ-01:2023
- Нислэгийн цаг уурын төвийн "Үйл ажиллагааны заавар" НЦУТ-АЗ-01:2022
- Нислэгийн цаг уурын төвийн "Сургалтын журам" НЦУТ-БЖ-019:2023
- Нислэгийн цаг уурын төвийн "Баримт бичгийн хяналтын журам" НЦУТ-БЖ-001:2024
- Нислэгийн цаг уурын төвийн "Бүртгэл хяналтын журам" НЦУТ-БЖ-002:2024
- Нислэгийн цаг уурын төвийн "Үл тохирох бүтээгдэхүүний журам" НЦУТ-БЖ-004:2024
- Нислэгийн цаг уурын төвийн "Дотоод аудитын журам" НЦУТ-БЖ-003:2023
- Нислэгийн цаг уурын төвийн "Залруулах арга хэмжээний журам" НЦУТ-БЖ-005:2024
- Нислэгийн цаг уурын төвийн "Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны журам" 2023, ИНД-100, ИНД-174.77

- MNS ISO/TR 10013 : 2001 Чанарын удирдлагын тогтолцооны баримт бичигт зориулсан аргазүйн зарчим
- MNS ISO 9001:2016 Чанарын удирдлагын тогтолцоо, шаардлага
- MNS ISO 9000:2017 Чанарын удирдлагын тогтолцоо, Үндсэн ойлголт ба тайлбар толь
- MNS ISO 19011:2016 Удирдлагын тогтолцоонд аудит явуулах заавар
- MNS ISO 9004:2016, MNS ISO / TR 10017:2005, MNS ISO 10005:1997
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай хууль
- Галын аюулгүй байдлын тухай хууль (холбогдох заалтууд)



## 1.3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү чанарын гарын авлагад Нислэгийн цаг уурын төвийн Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар, Үйл ажиллагааны заавар, “Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам”-д байгаа тодорхойлолтуудаас гадна дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.



### **Аудит**

Аудитын нотолгоог олж, энэ нь аудитын шалгууртай ямар хэмжээнд нийцэж буйг бодитойгоор тогтоох байнгын бие даасан, баримтжуулсан үйл явц.



### **Аудитын шалгуур**

Аудитын нотолгоог харьцуулж ишлэл болгон ашиглах бодлого, журам эсвэл шаардлагын багц



### **Аудитын нотолгоо**

Аудитын шалгуурт хамаатай бөгөөд магадлан шалгах боломжтой бүртгэл, бодит байдлын тухай мэдэгдэл, эсвэл бусад мэдээлэл



### **Бүтээгдэхүүн**

Оролтыг гаралт болгон хувиргах харилцан үйлчлэл бүхий багц үйл ажиллагааны үр дүн. БҮТЭЭГДЭХҮҮН гэдэг нэр томъёо нь мөн-ҮЙЛЧИЛГЭЭ гэсэн утгыг илэрхийлнэ.

*Нислэгийн цаг уурын төвийн үйл ажиллагаанд БҮТЭЭГДЭХҮҮН гэдэг нь: Байгууллагын алба нэгжүүд, агаарын тээвэрлэгч, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын харилцан үйлчлэл бүхий үйл ажиллагаанаас гарах үр дүн болох багц үйлчилгээнүүд.*



### **Гэрээ**

Талууд тодорхой асуудлаар харилцан тохиролцсоны үндсэн дээр хүлээх эрх, үүрэг, хэрэгжүүлэх нөхцөл, хариуцлагыг тодорхойлж, хуулийн дагуу үйлдсэн баримт бичиг.

*Нислэгийн цаг уурын төвийн үйл ажиллагаанд ГЭРЭЭ гэдэг нь: Нэг талаас тус төв, нөгөө талаас хамтран ажиллаж буй агаарын тээвэрлэгч, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах, ашиглах талаар хамтран ажиллах харилцан үйлчлэл бүхий үйл явц.*



### **Санамж бичиг**

Талууд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг харилцан тохиролцож, бичгээр үйлдэж баталгаажуулсан баримт бичиг.



### **Журам**

Тодорхой үйл ажиллагаанд баримтлах дэг, горимыг тогтоосон баримт бичиг.



### **Зохион бүтээлт боловсруулалт**

Шаардлагыг бүтээгдэхүүн үйл явц буюу тогтолцооны тогтоосон үзүүлэлт буюу техникийн нөхцөлд шилжүүлэн хувиргах үйл явц.

*Нислэгийн цаг уурын төвийн үйл ажиллагаанд "ЗОХИОН БҮТЭЭЛТ БОЛОВСРУУЛАЛТ" гэдэг нь: Хэрэгцээ шаардлагаас урган гарч ирсэн үйлчилгээний технологи, журам, зааврыг холбогдох хууль дүрэм үндэсний болон олон улсын стандарт, мөн техникийн нөхцөлд тохируулан боловсруулах үйл явц.*



**"Тохирол"** шаардлага биелж байгаа байдал



### **Эрсдэл**

Зорилтуудад үзүүлэх тодорхой бус байдлын нөлөө



### **Чадамж**

Мэдлэг ба ур чадвараа төлөвлөсөн үр дүнд хүрэхэд хэрэглэх чадвар



### **Чадвар**

Аудитын явцад хувийн зан чанарыг зохистой байдлаар хэрэглэхийг ойлгоно.



**"Удирдлагын дүн шинжилгээ"** - Чанарын удирдлагын тогтолцооны үр нөлөөтэй, хангалттай, тохиромжтой байдлыг дээд удирдлагын зүгээс тогтмол үнэлэх ажиллагаа.



**"Үйл явц"** нөөц хэрэглэн оролтыг гаралт болгон хувиргах харилцан уялдаа буюу харилцан үйлчлэл бүхий багц үйл ажиллагаа.



**"Үл тохирол"** шаардлага үл биелж байгаа байдал.



**"Хэрэглэгч"** бүтээгдэхүүнийг авдаг байгууллага буюу хүн.

*Нислэгийн цаг уурын төвийн үйл ажиллагаанд ХЭРЭГЛЭГЧ гэдэг нь агаарын тээвэрлэгч, нисэх баг, багийн бүрэлдэхүүн, бусад харилцагч байгууллагууд хамаарна.*



### **Чанар**

Объектын хувийн багц үзүүлэлт нь шаардлагыг биелүүлэх хэр хэмжээ.

*Нислэгийн цаг уурын төвийн үйл ажиллагаанд ЧАНАР гэдэг нь: Байгууллагын үйл ажиллагааг аюулгүй, шуурхай, соёлтой, үр ашигтай зохион байгуулж, үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээний шаардлагыг биелүүлэх хэр хэмжээ.*



### **Чанарын удирдлагын тогтолцоо**

Байгууллагыг чанарын талаар удирдан чиглүүлэх, хянах удирдлагын тогтолцоо.



### **Чанарын бодлого**

Дээд удирдлагаас албан ёсоор томъёолон гаргасан бөгөөд чанарын талаар байгууллагын баримтлах үндсэн зорилт.



### **Чанарын тогтолцоо**

Чанарын удирдлага хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай нөөц болон технологи арга зам, технологи ажиллагаа, зохион байгуулалтын бүтэц бүхэлдээ чанарын тогтолцоо юм.



### **Чанарын гарын авлага**

Байгууллагын чанарын бодлогыг агуулсан бөгөөд чанарын тогтолцоог тайлбарласан баримт бичиг.



### **Чанарын менежер**

Чанарын удирдлагын тогтолцоо болон түүний хэрэгжилтийг хариуцсан дээд удирдлагатай шууд харьцах ажилтан.



### **Чанар сайжруулалт**

Тухайн байгууллага ба хэрэглэгчийн аль алинд нь илүү ашигтай болгохын тулд үйл ажиллагаа ба үйл явцын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхээр бүх байгууллагын хэмжээнд авч хэрэгжүүлдэг арга хэмжээ.



**"Шаардлага"** Гол төлөв мэдээжийн буюу албан журмын шинжтэй, тогтоосон хэрэгцээ буюу хүсэл.

*Нислэгийн цаг уурын төвийн үйл ажиллагаанд ШААРДЛАГА нь: Байгууллагын үйл ажиллагааг олон улсын болон үндэсний стандарт, нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй ажиллагааны хэм хэмжээнд нийцүүлэн тогтоосон хэрэгцээ буюу хүсэл.*



## 1.4 Товчилсон үгс

<b>АБЧМ</b>	- Аюулгүй байдал, чанарын менежер
<b>АБЧУЗ</b>	- Аюулгүй байдал, чанарын удирдлагын зөвлөл
<b>АБЧХАМ</b>	- Аюулгүй байдал, чанарын хяналтын ахлах мэргэжилтэн
<b>АБЧХХ</b>	- Аюулгүй байдал, чанарын хяналтын хэсэг
<b>АЗ</b>	- Ажлын заавар
<b>БЖ</b>	- Баримтжуулсан журам
<b>ДЦУБ</b>	- Дэлхийн Цаг Уурын Байгууллага
<b>ЗСААХ</b>	- Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс
<b>ИНД-174</b>	- Иргэний нисэхийн дүрэм-174
<b>ИНЕГ</b>	- Иргэний нисэхийн ерөнхий газар
<b>ИТА</b>	- Инженер, техникийн ажилтан
<b>ISO</b>	- International organization for standardization
<b>МҮХ</b>	- Мэдээлэл, үйлчилгээний хэлтэс
<b>МНС</b>	- Mongolian national standard
<b>МУЛЦУС</b>	- Морин-Уул локатор, цаг уурын станц
<b>НБ</b>	- Нисэх буудал
<b>НЦУТ</b>	- Нислэгийн цаг уурын төв
<b>НЦУБАҮХ</b>	- Нисэхийн цаг уурын бодит ажиглалтын үйлчилгээний хэсэг
<b>ОУИНБ</b>	- Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага
<b>ОУНБ</b>	- Олон улсын нисэх буудал
<b>СМСИ</b>	- Сүлжээ, мэдээллийн сангийн инженер
<b>СМТАИ</b>	- Сүлжээ, мэдээллийн технологийн ахлах инженер
<b>УЦУОШТ</b>	- Ус цаг уур, орчны шинжилгээний төв
<b>УЦУОСМХ</b>	- Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
<b>ЦУОШГ</b>	- Цаг уур, орчны шинжилгээний газар
<b>ЧГА</b>	- Чанарын гарын авлага
<b>ЧУТ</b>	- Чанарын удирдлагын тогтолцоо



## БҮЛЭГ 2

# Байгууллагын төлөв байдал



## 2.1. Байгууллагын төлөв байдал



## 2.2 Сонирхогч талууд

Байгууллага нь чанарын удирдлагын тогтолцоонд хамаарах сонирхогч талуудыг тодорхойлсон байна. Үүнд: Сонирхогч тал нь дараах шаардлагуудыг хангасан байна.


- Бүтээгдэхүүн үйлчилгээний үйл явцад нөлөөлөх
- Нөөцөд нөлөөлөх
- Удирдлагын шийдвэрт нөлөөлөх

## 2.3 Чанарын удирдлагын тогтолцооны хамрах хүрээ

	<b>Information dissemination service - Мэдээлэл түгээх үйлчилгээ</b>
	<b>Meteorological reporting service - Цаг уурын мэдээний үйлчилгээ</b>
	<b>Meteorological briefing service - Цаг уурын мэдээний зааварчилгаа өгөх үйлчилгээ</b>
	<b>Climatology service - Уур амьсгалын мэдээний үйлчилгээ</b>
	<b>Meteorological watch service - Цаг уурын ажиглалтын үйлчилгээ</b>
	<b>Forecast service - Урьдчилан мэдээлэх үйлчилгээ</b>



## 2.4 Чанарын удирдлагын тогтолцоо ба үйл явц





## БҮЛЭГ 3

# Манлайлал



### 3.1 Манлайлал ба амлалт


3.1.1 НЦУТ–ийн дарга (даргын зөвлөл) нь чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхдээ дараах чиг үүргийг дэмжих зэргээр өөрийн хариуцлагын хүрээнд манлайллыг үзүүлнэ. Үүнд:

- a) Чанарын удирдлагын тогтолцооны үр нөлөөтэй байдлыг хариуцах;
- b) Байгууллагын төлөв байдал, стратегийн чиглэлтэй уялдсан чанарын удирдлагын тогтолцооны бодлого, зорилтуудыг бий болгохыг хариуцах;
- c) Чанарын удирдлагын тогтолцооны шаардлага нь байгууллагын чиглэл, үйл явцад нийцүүлж, нэгтгэх нөхцөлөөр хангах;
- d) Үйл явцын хандлага, эрсдэлд суурилсан сэтгэлгээг дэмжих;
- e) Чанарын удирдлагын тогтолцооны шаардлагатай нөөцийн бэлэн байдлыг хангах;
- f) Үр нөлөөтэй чанарын удирдлага ба чанарын удирдлагын тогтолцооны шаардлагын нийцлийн ач холбогдлыг ойлгуулсан байх;
- g) Чанарын удирдлагын тогтолцоо төлөвлөсөн үр дүнд хүрэх нөхцөлийг бүрдүүлэх;
- h) Чанарын удирдлагын тогтолцоог үр нөлөөтэй байлгахын тулд ажилтнуудын оролцоог хангах, чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх;
- i) Сайжруулалтыг урамшуулах;
- j) Бусад холбогдох удирдах чиг үүргийг дэмжих;

#### 3.1.2 Хэрэглэгчид анхаарлаа төвлөрүүлэх

НЦУТ нь нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, үйлчлүүлэгч, хэрэглэгчдийнхээ одоогийн болон ирээдүйн хэрэгцээ шаардлагыг биелүүлэх, хэрэглэгчийн хүсэлд нийцэх нөхцөлийг бий болгохыг хичээн ажиллана.

Хэрэглэгчид, харилцагчидтай дараах зарчмаар хамтран ажиллана.



НЦУТ нь үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хамтран ажиллах гэрээнд тусгасан болно.



### 3.2 Чанарын бодлого

НЦУТ-ийн дарга нь чанарын бодлогоо дараах байдалтай байлгах арга хэмжээг авна. Үүнд:

Байнга шинээр сурч, чадваржиж буй хүний нөөц, шинэ мэдээлэл, дэвшилтэд технологийг ашиглан:

- a) Байгууллагын зорилго, төлөв байдалд тохирсон стратегийн чиглэлийг дэмжих;
- b) Чанарын удирдлагын тогтолцоогоо MNS ISO 9001:2016 стандартын шаардлагад нийцүүлж, үр нөлөөг нь байнга сайжруулах тухай амлалт агуулж байх;
- c) Чанарын зорилтуудыг (4.2)-ын дагуу тогтоох, тэдгээрт дүн шинжилгээ хийх хүрээг тогтоож өгсөн байх;
- d) Холбогдох сонирхогч талуудад боломжоороо хүртээмжтэй байх;



**Нислэгийн цаг уурын төвийн ЧАНАРЫН БОДЛОГО нь нислэгт аюулгүй ажиллагаа хангасан цаг уурын үйлчилгээг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үзүүлж, хэрэглэгч**

**дийг олон улсын чанарын стандартыг хангасан цаг агаарын мэдээ мэдээллээр шуурхай үйлчлэхэд оршино.**

Бид Чанарын удирдлагын тогтолцоог MNS ISO 9001:2016 стандартын шаардлагад нийцүүлэн, байнга сайжруулах замаар нислэгийн аюулгүй ажиллагааг хангасан цаг уурын мэдээ мэдээллийг сүүлийн үеийн шинэлэг, дэвшилтэд технологиудад суурилан хүргэж хэрэглэгч нэг бүрийн сэтгэл ханамжийг өндөр байлгахад ямагт анхаарч ажиллана.



НЦУТ нь хэрэглэгчийн хүсэл, шаардлага, холбогдох хуульд нийцүүлэн үйл ажиллагаагаа ханган биелүүлэхийн тулд бүхий л шатанд ажил үйлчилгээгээ хянаж байхаар чанарын удирдлагын тогтолцоог хэвшүүлж ажиллана.

НЦУТ-ийн дарга нь чанарын удирдлагын тогтолцоог байнга сайжруулах явцад манлайлна. Манай төвийн чанарын удирдлагын тогтолцоо нь Олон улсын ISO 9001:2015 стандартад нийцсэн, бүрэн хэмжээгээр баримтжуулсан тогтолцоо болно.

### 3.3 Байгууллага дахь үүрэг хариуцлага, эрх мэдэл

#### Үүрэг хариуцлага, эрх мэдэл


НЦУТ-ийн дарга нь чанарын удирдлагын тогтолцооны хүрээнд нийт ажилтан, албан хаагчдын үүрэг хариуцлага, эрх мэдлийг байгууллагын хэмжээнд бүрэн тодорхойлж, мэдээлнэ. Төвийн хэмжээнд чанарт хамаарах үйл ажиллагааны хариуцлагыг дараах байдлаар хүлээнэ. Үүнд:



### 3.3.1 Дарга:




### 3.3.2 Аюулгүй байдал, чанарын менежер:






### 3.3.3 Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс:



### 3.3.4 Хэлтэс, нэгжийн дарга:



### 3.3.5 Нийт албан хаагчид

- Төвийн бүх шатны албан хаагчид нь өөрийн хариуцсан ажлаа холбогдох дүрэм, журамд нийцүүлэн чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх;
- Төвийн нийт албан хаагчид нь чанарын холбоотой асуудлаар шууд өөрийн удирдлага болон чанарын удирдлагын багтай харьцан ажиллах;
- Өөрийн үйл ажиллагаанд холбоотой дүрэм, журмыг ажлын байранд тогтмол хэрэгжүүлэх;
- Аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын заавруудыг чанд мөрдөн ажиллах;
- Үйл ажиллагаанд гарах үл тохирлыг хэлтэс нэгжийн удирдлага, чанарын багийн гишүүдэд мэдээлэх;
- Чанарыг сайжруулах, үйлдвэрлэлд шинэ санаа, технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох;



- g) Бүхий л хугацаанд чанарын удирдлагын тогтолцооны шаардлагуудыг мөрдөж ажиллах;
- h) Чанарын асуудалд хүргэх аливаа будилаан, үйл явцыг холбогдох удирдлагад мэдээлэх;
- i) Тоног төхөөрөмжийн хүчин чадлыг бүрэн ашиглах, тоног төхөөрөмжийг засварлах, аюулгүй ажиллагааны дүрмийг хангаж ажиллана;

Үүнд:

- Төвийн даргын зөвлөлөөс Аюулгүй байдал, чанарын зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулна.
- Аюулгүй байдал, чанарын зөвлөлийн гишүүд нь MNS ISO 9001:2016 стандартын ерөнхий нөхцөл шаардлагыг хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ.




# БҮЛЭГ 4

# Төлөвлөлт




#### 4.1 Эрсдэл ба боломж

Байгууллага чанарын удирдлагын тогтолцоог төлөвлөхдөө 2.1-д заасан асуудлууд, 2.2-т өгсөн шаардлагыг үндэслэн эрсдэл болон боломжуудыг тодорхойлоход дараах асуудлаар авч үзнэ.



Байгууллага нь дараах арга хэмжээг төлөвлөнө.



Эрсдэл болон боломжуудыг авч үзэх арга хэмжээнүүд нь бүтээгдэхүүн, үйлчилгээний тохиролд үзүүлэх нөлөөлөлтэй уялдсан байна.

**ТАЙЛБАР 1 Эрсдэлийг** авч үзэх сонголт гэдэгт эрсдэлээс зайлсхийх, боломж хайхын тулд эрсдэл хийх, эрсдэлийн эх үүсвэрийг арилгах, эрсдэлийн магадлал буюу үр дагаврыг өөрчлөх, эрсдэлийг хуваалцах, шийдвэрийг ил тод байлгах замаар эрсдэлийг тогтоон барих зэрэг асуудал хамаарна.

**ТАЙЛБАР 2 Боломж** нь шинэ туршлагыг нутагшуулах, шинэ бүтээгдэхүүн гаргах, шинэ зах зээл нээх, шинэ хэрэглэгчид чиглүүлэх, түншийн харилцаа бий болгох, шинэ технологи хэрэглэх болон байгууллагын эсвэл хэрэглэгчдийн хэрэгцээнд чиглэсэн бусад бодит, тааламжтай бололцоонуудыг ашиглахад чиглэнэ.

#### 4.2 Чанарын зорилт


НЦУТ нь чанарын удирдлагын тогтолцоонд шаардлагатай холбогдох чиг үүрэг, түвшин, үйл явцууд дахь чанарын зорилтуудыг тогтооно.

Чанарын зорилтууд:

- а) чанарын бодлоготой уялдсан;
- б) хэмжигдэхүйц;
- в) холбогдох шаардлагыг авч үзсэн;



- d) бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд хамааралтай;
  - e) хянагддаг;
  - f) мэдээлэгдсэн;
  - g) шаардлагатай тохиолдолд шинэчлэгддэг байна
- Байгууллага нь чанарын зорилтуудыг баримтжуулж, мөрдөнө.



### Чанарын зорилт

- Төвөөс гаргаж буй урьдчилсан мэдээний таарцыг өмнөх жилээс 0,01%-иар нэмэгдүүлэх.
- Албан хаагчдын мэргэжил, мэдлэг, чадавхыг дээшлүүлэх, төлөвлөгөөний дагуу сургалтад хамрагдах
- Үйл ажиллагаанд ашиглагдаж буй заавар, журамд шинэчлэлт, өөрчлөлтийг цаг тухайд нь сайжруулан хийж, даган мөрдөх.
- Цаг агаарын мэдээнээс шалтгаалсан нислэгийн саатлын чанарыг 1%-иар бууруулах.
- Нислэгийн цаг уурын үйлчилгээг сайжруулах үе шаттай үйл ажиллагааг явуулах.



World Meteorological Organisation



### 4.3 Өөрчлөлтийг төлөвлөх

НЦУТ нь чанарын удирдлагын тогтолцоондоо өөрчлөлт хийх шаардлагатай гэж тодорхойлсон бол түүнийгээ төлөвлөнө. Үүнд:



Өөрчлөлт хийх зорилго, түүнээс гарах боломжит үр дагаврууд



Чанарын удирдлагын тогтолцооны нэгдмэл байдал



Нөөцийн бэлэн байдал



Үүрэг хариуцлага болон эрх мэдлийн хуваарилалтыг дахин хийх



# БҮЛЭГ 5

## Тулгуур хүчин зүйл

## 5.1 Нөөц

### 5.1.1 Ерөнхий

НЦУТ нь чанарын удирдлагын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, цаашид үргэлжид сайжруулахад шаардлагатай нөөцийг тодорхойлж, түүгээр хангаж ажиллана. Үүнд:

- Байгаа дотоод нөөц бололцоо ба хязгаарлагдмал байдал
- Гаднын нийлүүлэгчээс авах хэрэгцээт зүйлс гэсэн асуудлуудыг авч үзнэ.

### 5.1.2 Хүний нөөц

НЦУТ нь чанарын удирдлагын тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлэх болон үйл явцын хяналт ба ажиллагаанд шаардагдах хүний нөөцийг тодорхойлж, хангана.




Албан хаагчид нь тохирох боловсрол, сургалт, дадлага, туршлагад суурилсан ур чадвартай байна. Төвийн дарга нь жил бүрийн сургалтын төлөвлөгөөг холбогдох хэлтэс, салбарын дарга нартай хамтран гаргаж, хэрэгжүүлэн ажиллана. Албан хаагчдын сургалттай холбогдол бүхий асуудлыг төвийн хүний нөөц хариуцсан ажилтан хариуцан зохион байгуулж, холбогдох бүртгэлийг хөтлөх, хадгалах,

баяжуулах үүрэгтэй.

### 5.1.3 Дэд бүтэц

НЦУТ нь үйл явцыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирсон байлгахад шаардлагатай дэд бүтцийг тодорхойлж, бий болгож хэвийн ажиллуулна. Үүнд:

- НЦУТ нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шаардлага хангасан зориулалтын барилга, байгууламж, ажиглалтын талбай, итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулагдсан тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэлтэй байна.
- Бодит болон урьдчилсан мэдээ гаргахад шаардлагатай зориулалтын суурин болон зөөврийн тоног төхөөрөмж, хэмжилтийн багаж хэрэгсэлтэй байна.
- Мэдээлэл хүлээн авах, дамжуулахад шаардлагатай сүлжээ, холбооны хэрэгсэлтэй байна.





#### 5.1.4 Үйл явцыг хэрэгжүүлэх орчин

НЦУТ нь үйл явцуудыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирсон байлгахад шаардлагатай орчныг тодорхойлж, бий болгож, хэвийн байлгана. Үүнд:

- a) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцсэн ажлын байртай байна.
- b) Ажилтнуудын ажил, үйлчилгээ явуулахад тохирсон стандартын шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл бусад эд зүйлсээр бүрэн хангасан байна.



#### 5.1.5 Мониторинг ба хэмжилтийн нөөц

НЦУТ нь бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлагад тохирч байгааг нотлоход ашиглаж байгаа мониторинг, хэмжилтийн үр дүнгийн хүчин төгөлдөр, найдвартай байдлыг хангахад шаардлагатай нөөцийг тодорхойлж, хангана. Нөөц дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- a) Хяналт, хэмжилтийн үйл ажиллагааны онцлог, төрөлд тохирсон байх;
- b) Зориулалтаар нь тогтмол ашиглах бололцоог хангахуйц хэвийн ажиллагаатай байх;
- c) Мониторинг, хэмжилтийн нөөцийн шаардлага хангаж байгааг нотлох баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгалах;

Бүтээгдэхүүнд болон цаг уурын үзэгдэл элементийн хэмжилт нь тохиролд нийцсэн байдлыг хангаж ажиллахын тулд ажиглах, хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулгыг хийх дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- a) Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгыг тогтоосон хугацаанд мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагаар хийж гүйцэтгүүлэн (автомат станц AWS330, AWS310, MILOS520, MAWS301, бусад хэмжилтийн багаж) ашиглана.
- b) Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгыг дахин хийлгэх шаардлагатай үед
  - Баталгаат хугацаа нь дууссан;
  - Хэмжих хэрэгсэл нь алдаатай хэмжиж байгаа нь нотлогдсон;
  - Бүтээгдэхүүний чанарт нөлөөлсөн нь туршилтаар нотлогдсон;
  - Тоног төхөөрөмж болон хэмжих хэрэгсэлд эвдрэл гарсан.
- c) Дүн шинжилгээ хийсэн тэмдэглэгээг хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжид нэг бүрчлэн тэмдэглэн үзлэг шалгалтын дэвтэрт бичилт хийнэ.
- d) Хэмжилтийн үр дүн, тохируулга алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч лац, ломбо тавьж тэмдэглэгээг шаардлагын дагуу бүртгэж хадгална.
- e) Баталгаажсан тоног төхөөрөмжийг тээвэрлэх, хадгалах нөхцөлд тээврийн хэрэгсэл болон агуулахад зориулалтын сав баглаа боодлыг ашиглан гэмтэхээс хамгаалах арга хэмжээг авсан байна.

Үйлдвэрлэлийн нарийн хэмжих хэрэгсэл компьютерын программ хангамж, баталгаажуулалтын үр дүн, түүний хүчин төгөлдөр байдал, бүтээгдэхүүний шаардлагыг үнэлж бүртгэнэ.



### 5.1.6 Байгууллага дахь мэдлэг

НЦУТ нь үйл явцыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирсон байлгахад шаардлагатай мэдлэгийг тодорхойлсон байна. Энэ мэдлэгийг шаардлагатай хэмжээнд хүртээмжтэй байлгаж, хэрэглэнэ. Хэрэгцээ, хандлагын өөрчлөлтөд нийцүүлэхэд шаардлагатай аливаа нэмэлт мэдлэгийг олж авах, байгаа мэдлэг дээрээ үндэслэн хэрхэн баяжуулж нэвтрэх аргыг тодорхойлно.

НЦУТ-ийн мэдлэг бол байгууллагад хамаарах, зорилтуудыг хангахад ашигладаг, хуваалцдаг мэдээлэл бөгөөд дараах зүйлд үндэслэгдэнэ. Үүнд:

- а) дотоод эх үүсвэр (оюуны өмч; туршлага

хуримтлуулсан мэдлэг; алдаа, амжилтын сургамж; баримтжуулаагүй боловч хуваалцаж болох мэдлэг, туршлага; үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний сайжруулалтын үр дүн гэх мэт);



- б) гадаад эх үүсвэр (стандартууд эрдэм шинжилгээний ажил; бага хурал; хэрэглэгч болон гаднын нийлүүлэгчдээс олж авсан мэдлэг гэх мэт)

### 5.2 Чадамж

НЦУТ-ийн нийт албан хаагчдын шаардагдах чадамжийг албан тушаалын тодорхойлолт, Сургалтын журамд тодорхойлон тусгасан байна. Үүнд:

- а) чанарын удирдлагын тогтолцооны гүйцэтгэл болон үр бүтээлтэй байдалд нөлөөлөх ажлыг өөрийн хяналт дор хийж байгаа ажилтны ур чадварт тавих шаардлагыг тодорхойлох;
- б) зохих боловсрол, сургалт, туршлагад үндэслэн эдгээр ажилтнуудын чадамжийг магадлах;
- с) боломжтой бол, шаардлагатай чадамжийг эзэмшүүлэх арга хэмжээ авах ба эдгээр арга хэмжээний үр бүтээлтэй байдлыг үнэлэх;
- д) чадамжийг нотлох холбогдох баримтжуулсан мэдээллийг хадгалах.

**ТАЙЛБАР:** Боломжтой арга хэмжээ гэдэгт сургалт явуулах, чиглүүлэх, одоо ажиллаж байгаа ажилтнуудыг өөр ажилд томилох, ур чадвартай ажилтныг ажилд авах эсвэл гэрээгээр ажиллуулах зэрэг байж болно.

### 5.3 Мэдлэг ойлголт

АБЧМ нь нийт албан хаагчдад дараах зүйлийг мэдүүлж, ойлгуулна. Үүнд:

- а) Чанарын бодлого;
- б) Холбогдох чанарын зорилтууд;
- с) Гүйцэтгэлээ сайжирсны үр ашгийг хамруулсан, чанарын удирдлагын тогтолцооны үр нөлөөнд тэдгээрийн үзүүлэх хувь нэмэр;
- д) Чанарын удирдлагын тогтолцооны шаардлагыг хангаагүйгээс гарах үр дагавар;

Албан хаагчдын шаардагдах мэдлэг ойлголтыг албан тушаалын тодорхойлолт, Сургалтын журамд тодорхойлон тусгана.

- а) Мэргэжлийн сургалт явуулах;
- б) Дурдсан шаардлагыг хангаж буй эсэхийг шалгаж батлахад чиглэсэн сургалт явуулах буюу бусад арга хэмжээг авах;



- c) Сургалтын үр дүн болон авсан арга хэмжээнийхээ үр нөлөөг үнэлэх;
- d) Албан хаагчдын үйл ажиллагааны хамаарал, ач холбогдол, чанарын зорилтыг биелүүлэхэд хэрхэн хувь нэмрээ оруулахыг нь албан хаагчдад ойлгуулах;
- e) Албан хаагчдын боловсрол, сургалт, дадлага, туршлагын талаарх зохих бүртгэлийг Сургалтын журмын дагуу хөтөлж хадгална.

## 5.4 Холбоо харилцаа

НЦУТ нь чанарын удирдлагын тогтолцоонд хамаарах дотоод болон гадаад холбоо харилцааны асуудлыг тодорхойлно. Үүнд:

- a) юу мэдээлэх;
- b) хэзээ мэдээлэх;
- c) хэнд мэдээлэх;
- d) хэрхэн мэдээлэх;
- e) хэн мэдээлэх зэрэг асуудлууд багтана.

Нийт албан хаагчдад мэдээллийг цахим шуудан, мэдээллийн самбар, утсан холбоо, цахим сүлжээ гэх мэт мэдээллийн хэрэгслийг ашиглан хурдан шуурхай хүргэнэ. НЦУТ-ийн дарга нь мэдээллийг бүх албан хаагчдын хурал хийж, дараах асуудлыг мэдээлж хүргүүлнэ. Үүнд:

- Байгууллагын хэмжээнд гарч буй өөрчлөлтүүд болон чанар сайжруулах ажлын үр дүн;
- Чанартай холбоотой дүрэм, журам, заавар нь төвийн үйл ажиллагаанд нийцэж байгаа байдал;
- Чанарын удирдлагын үр нөлөө.

Төвийн гадаад харилцаа нь хэрэглэгчидтэй харилцах дараах үр нөлөөтэй арга хэрэгслийг тодорхойлж хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) Бүтээгдэхүүний талаарх мэдээллийг төвийн танилцуулга, цахим хуудас ([www.amc.naem.gov.mn](http://www.amc.naem.gov.mn))-аар, салбарын чиглэлээр зохиогдож буй үзэсгэлэн яармаг, тусгай уулзалтаар хүлээн авч дэлгэрэнгүй танилцуулах;
- b) Гэрээний нэмэлт шаардлага, бүтээгдэхүүний захиалгыг албан бичгээр хүлээн авах, хариуг албан бичгээр буцаан өгөх ба гэрээ байгуулах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах зэргээр шийдвэрлэнэ;
- c) Хэрэглэгчээс ирсэн санал, гомдлыг хугацаа алдахгүй хүлээн авч, холбогдох журмын дагуу арга хэмжээ авч, шийдвэрлэн түүний мэдээллийг тогтмол хийж, энэ талаарх бүртгэлийг хөтөлнө;
- d) Үйлдвэрлэлийн үйл явцтай танилцах, айлчлал зохион байгуулах.





## 5.5 Баримтжуулсан мэдээлэл

### 5.5.1. Ерөнхий зүйл

НЦУТ-ийн чанарын удирдлагын тогтолцооны баримтжуулсан мэдээлэл нь дараах зүйлүүдээс бүрдэнэ. Үүнд:

- a • Чанарын бодлого, зориултуудын баримтжуулсан тунхаглал
- b • Чанарын гарын авлага (энэхүү баримт бичиг)
- c • Энэхүү гарын авлагын дагуу шаардагдах баримтжуулсан журмууд
- d • Ажлын заавар, ашиглалтын заавар
- e • Энэхүү гарын авлага болон бусад баримт бичгийн дагуу шаардагдах бүртгэлүүд (Чанарын баримт бичиг, бүртгэл хяналтын журам)
- f • Байгууллагын үйл явцыг үр нөлөөтэйгээр төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах зориулалттай бусад баримт бичиг

Төвийн чанарын удирдлагын тогтолцооны баримт бичгүүдийн жагсаалтыг Хавсралт №3-аар харуулав.

### 5.5.2. Чанарын гарын авлага


НЦУТ нь өөрийн үйл ажиллагаанд нийцсэн чанарын гарын авлагыг бий болгон, хэрэгжүүлж, хадгалж болно.

Энэхүү чанарын гарын авлага нь чанарын удирдлагын тогтолцооны бодлого, зорилт, хамрах хүрээ, баримтжуулсан журмууд тэдгээрийн иш таталт, үйл явцуудын хоорондын уялдааг тодорхойлно.

Чанарын удирдлагатай холбогдсон үндсэн баримт бичиг болох чанарын гарын авлагыг Аюулгүй байдал, чанарын менежер боловсруулах, хянах, сайжруулах ажиллагааг тогтмол хийх ба төвийн даргад танилцуулж баталгаажуулна.

Чанарын гарын авлагад орох өөрчлөлтийн саналыг төвийн аль ч нэгж гаргаж болох ба өөрчлөлт орох эсэхийг чанарын баг хэлэлцэж ажлын 20 хоногийн дотор шийдвэрлэнэ. Өөрчлөлт батлагдсан тухай бүр нь төвийн нийт албан хаагчдад мэдээлж танилцуулна.

### Чанарын гарын авлага



- 51-ээс дээш хувьд нь өөрчлөлт орохоор бол түүнийг шинэчлэн батална
- Бусад тохиолдолд өөрчлөлт хэлбэрээр батална



### 5.5.3. Баримтжуулсан мэдээллийг хянах

НЦУТ–ийн чанарын удирдлагын тогтолцоонд шаардагдах баримт бичгүүд нь хяналттай байна. Чанарын бүртгэл нь баримт бичгийн тусгай төрөл бөгөөд Баримт бичгийн хяналтын журмын дагуу хянаж хэрэгжүүлнэ.

Дараах зүйлд шаардагдах хяналтыг тодорхойлох зорилгоор баримтжуулсан журам бий болгон мөрдөнө. Үүнд:

- a) Баримт бичгийг хэвлэхээс өмнө хангалттай эсэх талаас нь хянаж баталж байх;
- b) Баримт бичигт дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол шинэчилж, дахин баталж байх;
- c) Баримт бичгийн өөрчлөлт, хянаж шинэчилсэн төлөв байдлыг тодорхой байлгах;
- d) ЧУТ-ны нийт баримт бичгийн нийцтэй байдлыг АБЧМ хянаж байх;
- e) Хэрэгцээт баримт бичгийг хэрэглэх газарт нь зохих хувилбараар нь бэлэн байлгах;
- f) Баримт бичгийг гаргацтай тод бөгөөд ялган таньж олоход хялбар байлгах;
- g) Гаднын гаралтай баримт бичгийн хүчин төгөлдөр байдалд хяналт тавьж байх;
- h) Гаднын гаралтай баримт бичгийг бүртгэж тодруулан тэдгээрийн түгээлтийг хяналттай байлгах;
- i) Хуучирсан баримт бичгийг санамсаргүй хэрэглэхээс сэргийлж, хэрэв аливаа нэгэн зорилгоор хадгалж байгаа бол тэдгээрийг сайтар бүртгэн тэмдэгжүүлэх.

### 5.5.4. Чанарын бүртгэлийн хяналт

НЦУТ–ийн чанарын удирдлагын тогтолцоо нь шаардлагад тохирч, үр нөлөөтэй хэрэгжиж байгаагийн баталгаа болгохын тулд бүртгэлийг бий болгон хадгална. Чанарын бүртгэл нь гаргацтай тод бөгөөд ялган таних, олж авахад хялбар хэвээр байвал зохино.

Ялган таних, хадгалах, хамгаалах, олж авах, хадгалах хугацаа болон устгахад шаардагдах хяналтыг Бүртгэл хяналтын журмын дагуу хэрэгжүүлнэ.




## БҮЛЭГ 6

# Ажиллагаа



## 6.1 Ажиллагааны төлөвлөлт ба хяналт

НЦУТ нь чанарын бодлого, чанарын зорилтоо нийцүүлэн боловсруулсан “Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө”-ний дагуу бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний үйл явцыг жил бүр төлөвлөн явуулна. Энэ үйл явц нь “Үйл явцын дэс дараалал, харилцан үйлчлэлийн нөхцөл шаардлага”-ын дагуу чанарын удирдлагын тогтолцооны бусад үйл явцтай харилцан уялдаж нийцсэн байна.



Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төлөвлөлтөд дараах зүйлүүдийг тодорхой тусгана. Үүнд:

- a) Төвийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнүүд ИНД-174-ийн шаардлагыг бүрэн хангасан, гэрээт үйлчлүүлэгч байгууллагууд, хэрэглэгчээс тогтоосон нэмэлт шаардлагыг үндэслэн ажил үйлчилгээ, шаардлагатай мэдээ, мэдээллийн хангалтаар гэрээнд заасан үүргийн дагуу тогтмол найдвартай хангана. Нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэглэж байгаа тоног төхөөрөмжид тогтмол үзлэг шалгалтыг харьяалагдах итгэмжлэгдсэн лабораторид хийж гүйцэтгэн бүртгэж хадгална;
- b) Үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах шаардлага нь Монгол Улсын хууль “Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай”, “Иргэний нисэхийн тухай”, “Иргэний нисэхийн дүрэм”-ийн шаардлагыг бүрэн хангаж ажиллана;
- c) Бүтээгдэхүүн үйлчилгээнд тавигдах нэмэлт шаардлагыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан төвийн дотоод дүрэм, журмаар зохицуулна.

## 6.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлага

6.2.1 НЦУТ нь хэрэглэгчийн хүсэл сонирхол, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хамаарах дараах шаардлагыг тодорхойлно. Үүнд:



- a) Төвийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнүүд нь ИНД 174-ийн шаардлагыг бүрэн хангасан, гэрээт үйлчлүүлэгч байгууллагууд, хэрэглэгчээс тогтоосон нэмэлт шаардлагыг үндэслэн ажил үйлчилгээ, шаардлагатай мэдээ, мэдээллийн хангалтаар гэрээнд заасан үүргийн дагуу тогтмол найдвартай хангана. Нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэглэж байгаа тоног төхөөрөмжид тогтмол үзлэг шалгалтыг харьяалагдах итгэмжлэгдсэн лабораторид хийж гүйцэтгэн бүртгэж хадгална.
- b) Үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах шаардлага нь Монгол Улсын хууль “Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай”, “Иргэний нисэхийн тухай”, “Иргэний нисэхийн дүрэм”-ийн шаардлагыг бүрэн хангаж ажиллана.
- c) Бүтээгдэхүүн үйлчилгээнд тавигдах нэмэлт шаардлагыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан төвийн дотоод дүрэм, журмаар зохицуулна.

6.2.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаарах шаардлагад дүн шинжилгээ хийх

НЦУТ нь бүтээгдэхүүн үйлчилгээндээ хамаарах стандартын нөхцөл, шаардлагад дүн шинжилгээ хийх бөгөөд гэрээт, захиалагч үйлчлүүлэгч байгууллагад бүтээгдэхүүн нийлүүлэхээр эцэслэн шийдвэрлэхээс (тендерт



оролцох, гэрээ буюу захиалгыг хүлээн авах) өмнө явуулж, дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

- a) Бүтээгдэхүүний шаардлагыг тодорхойлон түүний эрэлт, гэрээт болон захиалагч байгууллагуудын хэрэгцээг судлан үзэж түүний тоо хэмжээ, нэр төрлийг хангалттай байлгаж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллах түүхий эдийн нөөцийг тогтмол бэлэн байлгаж ажиллана.
- b) Хэрэглэгч тал гэрээнд тусгагдсанаас өөр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ захиалах тохиолдолд түүний хэрэгцээг цаг хугацаа алдахгүй шийдвэрлэсэн байна.
